



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/288

Сүхбаатар сум

Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г", Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тсгтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд Сүхбаатар сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт авто машины гараашны зориулалтаар эзэмшүүлэхээр тусгагдсан 24м² талбай бүхий газрыг эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг явуулсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны тов, тухайн нэгж талбарын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, хугацаа, дэнчингийн хэмжээг нэгж талбар бүрээр энэхүү захирамжийн хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг товлогдсон хугацаанд журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 11 сарын 11-ны өдрийн
1/28 тоот захирамжийн 1-р хавсралт

Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

№	Дуудлага худалдаанд орох нэгж талбар		Дуудлага худалдааны тов	Дуудлага худалдааны анхны үнэ/ төг	Дуудлага худалдааны хэлбэр	Эзэмших Хугацаа	Дуудлага худалдааны дэнчингийн хэмжээ /төг/	
	Байршил	Хэмжээ /м2/						Зориулалт
1	Сумбаатар сумын Ган зам 7-р баг Хилчид 2-р гудамжны	24	2020.11.18	115200	Цахим	15	11520	
Нийт дүн							24	115200